

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Орхон аймгийн иргэний нийгмийн байгууллагууд,
эрдэмтэд, судалгааны байгууллагуудтай хийсэн уулзалт
2017 оны 9-р сарын 8

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлыг сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 8-нд Орхон аймгийн ИНБ, эрдэмтэн судлаачид ба сургалт судалгааны байгууллагын 10 төлөөлөгчтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1. Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2. Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3. Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний талаарх санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Бүс нутгийн хөгжил/төвлөрлийг сааруулах нь улс орны хөгжлийн үндэс суурь юм. Иймд ДБГ нь орон нутагт ирж, хүмүүсийн санал бодлыг сонсож байгаа нь өөрөө боломж юм. • Хангайн бүс нь хөгжлийн хувьд бусад бүс нутгуудаас түрүүлж байна. • Эрдэнэтийн ашигт малтмалын нөөцийг түшиглэн байгуулсан Эрдэнэт хот нь бүс нутгийн төв болох боломжтой. • Эрдэнэт хотын хүн амын нягтаршил, зах зээлийн төвлөрөл ихтэй учраас энэ бүсэд бизнес эрхлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд боломж бий. • Эрдэнэтийн уурхай нь чадварлаг ажиллах хүчин, хүний нөөцийг бий болгосон. Орон нутгийн их сургуулиуд/их дээд сургуулиудын салбарууд бий. Хүмүүсийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ЖДҮ-ийг дэмжих төслүүдийг хэрэгжүүлж болох юм. • Хөгжлийг дэмжихэд малыг ашиглах боломжтой. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт жишээ нь ЖДҮ-ийн түвшинд арьс шир, гэдэс боловсруулах гэх мэт. • Баялгийг бүтээхийн тулд хог хаягдлыг дахин боловсруулах/дахин ашиглах боломж бий. • Санхүүжүүлж болох төслийн бэлэн саналууд бий, тухайлбал гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн төсөл гэх мэт. • Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэхийн тулд худалдааны чөлөөт бүсийг бий болгох боломжтой. <p>Сорилтууд</p>

- Эрдэнэт хотын уул уурхайд суурилсан эдийн засаг нь байгаль орчны олон асуудал, тухайлбал байгаль орчныг нөхөн сэргээх, хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулахад суралцах хэрэгцээ шаардлагыг бий болгосон. Түүнчлэн цэвэр эрчим хүч болон сэргээгдэх эрчим хүчийг ихээр үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлж болно.
- Гэр хорооллын бохирдол нь Эрдэнэт хотын тулгамдсан нэг асуудал мөн. Өмнө хэрэгжүүлсэн цэвэр агаар төслүүд нь бодитой бус байсан. Орон нутгийн эрдэмтэд орон нутгийн нөхцөл байдлын талаар илүү сайн мэдээлэлтэй байдаг учраас илүү сайн шийдлийг санал болгох боломжтой боловч тэдэнд эрх тэгш боломж олгох, ЖДҮ санхүүжилт авах боломж хязгаарлагдмал хэвээр байна.
- ИНБ-ууд идэвхгүй сул, ажлын чанар муу хэвээр байна. Бүсийн хэмжээнд томоохон, илүү нөлөөтэй байгууллагууд одоог хүртэл алга байна. Иймд ИНБ-ын чадавхийг бэхжүүлэх нь бодит хэрэгцээ болж байна.
- Ядуурал тэлж, хүмүүсийн амьжиргаа доройтож байна. Өөрчлөлт хийх гэж яардаг; гэвч ядуурлыг эцэслэх нь урт хугацааны үйл явц гэдгийг ойлгох ёстой.
- Тэтгэврийн зээл авах нь ахмад настнуудын дунд түгээмэл байдаг. Ахмад настнууд хүүхдүүдийнхээ боловсрол, эрүүл мэндийн зардал болон бусад зардлыг төлөхөд туслахын тулд зээл авдаг, иймд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.
- Засаглал, шударга ёс ба тэгш байдлын үр дүнд хүрэх явдал сорилт болсоор байна. Авилгалын улмаас хүмүүст ихээхэн бэрхшээл тулгарч байна.
- Уул уурхай, хөдөө аж ахуйн нөөцийг зөв зохистой удирдахад улс төр саад болж байна.
- Тулгамдсан олон асуудлын дотор боловсрол хамгийн чухал асуудал юм. Бидний ирээдүй залуучуудын боловсролоос шалтгаална. Өнөөгийн боловсролын тогтолцоо, их дээд сургуулиуд хөдөлмөрийн зах зээл дээр шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгож чаддаггүй. Боловсролын тогтолцоог зөвхөн мэргэжлийн төдийгүй амьдрах ухааны чадвар олгоход чиглэсэн платформ болгож хөгжүүлэх хэрэгтэй. Ахлах сургууль төгсөгчдөд ирээдүйн ажил мэргэжлийн чиг баримжаа олгодоггүй, сонголт хийхэд нь зохистой чиглүүлж чаддаггүй. Боловсролын салбарын бодлого, хөтөлбөрүүд нь тогтворгүй учраас салбарын хэмжээнд олон сөрөг асуудлыг бий болгож байна. Боловсролын тогтолцоо нь үндэсний уламжлалт соёлын өвд тулгуурладаггүй.
- Дотоодын их дээд сургууль төгсөгчид нь гадаадад сургууль төгсөгчидтэй өрсөлдөх шударга бус өрсөлдөөнд хүчин мөхөсддөг. Монголын боловсролын үнэ цэнийг дээшлүүлэх хэрэгтэй.
- Ажлын байр дутагдалтай, цалин бага учраас олон монголчууд хилийн чанадад бага хөлстэй ажил эрхэлж байгаа нь тархи гадагшаа урсах буюу оюуны чадавхтай хүмүүс эрх орноо орхин гадагш гарснаар дотоодод оюуны хоосрол бий болоход хүргэж болзошгүй.
- Хүнсний болон замын аюулгүй байдал нь эрүүл мэндийн асуудал, хөгжлийн бэрхшээлийг үүсгэх гол шалтгаан болж байна.
- Хувийн эмнэлгүүдийн үйлчилгээ маш өндөр үнэтэй.
- Хөгжлийн зарим сорилтууд нь илэрхий байдаг ч зарим тулгамдсан асуудлууд нуугдмал хэвээр байна.

ДБГ-ийн стратеги ба түншлэлийн талаар санал	Салбарууд: <ul style="list-style-type: none"> • Засаглалын шинэчлэл: төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийг дэмжих. • Хөдөлмөр эрхлэлтийг бий болгоход түлхүү анхаарах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан анхаарч дэмжих хэрэгтэй. • Худалдааны салбарт системтэйгээр дэмжлэг үзүүлэх: худалдааны бүс бий болгох, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, үйлдвэрлэлийн үйл явцыг үргэлжлүүлэн дэмжих гэх мэт. • ЖДҮ-ийн санхүүжилт, техникийн туслалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд туслах, ЖДҮ-ийн салбарыг бүх талаар дэмжих. • Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах: сүү, арьс шир боловсруулах зэргээр эдийн засгийн боломж, ажлын байр бий болгох. • Хүний нөөцийн хөгжил: Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарыг цаашид хөгжүүлэх нь тэргүүлэх ач холбогдолтой. Мөн бага насны хүүхдийг багаас нь амьдрах ухааны ур чадварт сургахад чиглэсэн бага насны хүүхдийн сургалт хэрэгтэй байна. Цаашилбал эрүүл амьдралын хэв маягийг олж авах чиглэлээр олон нийтэд боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх нь чухал.
--	--

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Төрийн удирдлага/шинэтлэл	4	40%
— Боловсрол	4	40%
— Авилгатай тэмцэх	3	30%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	3	30%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	1	10%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	1	10%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	1	10%
— Эрүүл мэнд	1	10%
— Хүнсний аюулгүй байдал	1	10%
— Хотын хөгжил	1	10%
— Нийгмийн хамгаалал	1	10%
— Байгалийн нөөцийн удирдлага	0	0%
— Хөдөөгийн хөгжил	0	0%
— Эдийн засгийн өсөлт	0	0%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	0	0%
— Эрх тэгш боломжоор хангах	0	0%
— Санхүүгийн зах зээл	0	0%
— Гадаадын хөрөнгө оруулалт	0	0%
— Зам, тээвэр	0	0%

— Худалдаа, экспорт	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Ус, ариун цэврийн байгууламж	0	0%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	0	0%
— Бусад:	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	5	50%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	3	30%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	3	30%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	1	10%
— Дэд бүцтийн хөрөнгө оруулалтыг дэмжих	1	10%
— Дээрх бүгд чухал	0	0%